



МОНГОЛБАНКНЫ ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТУШААЛ

2012 оны 12 сарын 24 өдөр

Дугаар 4.197

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн 19¹ дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Зээлийн мэдээллийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.“Зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрлийн журам”-ыг хавсралтаар баталсугай.

2.Зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх этгээдийн өөрийн хөрөнгийн доод хэмжээг 1,000,000,000.00 (нэг тэрбум) төгрөгөөр, Монголбанкнаас зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрөл олгох ажил, үйлчилгээний шимтгэлийг 1,000,000.00 (нэг сая) төгрөгөөр тус тус тогтоосугай.

3.Энэ тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт шалгалтын газар (Б.Лхагвасүрэн)-т үүрэг болгосугай.

ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЗОЛЖАРГАЛ



Монголбанкны Ерөнхийлөгчийн
2012 оны 12 дугаар сарын 19-ны өдрийн
4 - 19 дугаар тушаалын хавсралт

**ЗЭЭЛИЙН МЭДЭЭЛЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ
ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ЖУРАМ**

НЭГ. Нийтлэг зүйл

- 1.1. Энэхүү журмын зорилго нь Зээлийн мэдээллийн тухай хуулийг хэрэгжүүлэх,
- 1.2. Монголбанкнаас зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрөл /цаашид тусгай зөвшөөрөл гэх/ олгох, олгосон тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох, тусгай зөвшөөрөл бүхий аж ахуй нэгжийн үйл ажиллагаанд хяналт тавих харилцааг зохицуулахад оршино.
- 1.3. Монголбанк нь тусгай зөвшөөрөл авах тухай аж ахуйн нэгжээс ирүүлсэн хүсэлтийг энэ журмын дагуу хүлээн авч, хянан шийдвэрлэнэ.
- 1.4. Хуульд өөрөөр заагаагүй бол Монголбанк тусгай зөвшөөрлийг аж ахуйн нэгжид олгоходоо хууль, журамд заасан шаардлагыг ижил тэгш баримтлана.
- 1.5. Энэ журамд заасан нэр томьёог дор дурьдсан утгаар ойлгоно:
 - 1.5.1. “Зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх этгээд” гэж Зээлийн мэдээллийн тухай хуулийн 4.1.5-д заасныг;
 - 1.5.2. “Эрх бүхий албан тушаалтан” гэж Компанийн тухай хуулийн 84.1-т заасныг;
 - 1.5.3. “Хувьцаа эзэмшигч” гэж компанийн хувьцааг шууд болон шууд бус хэлбэрээр эзэмшиж байгаа иргэн, хуулийн этгээдийг.

ХОЁР. Зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрөл олгоход тавигдах шаардлага, бүрдүүлэх баримт бичиг

- 2.1. Зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх этгээд нь хязгаарлагдмал хариуцлагатай компани хэлбэрээр байгуулагдаж үйл ажиллагаа явуулна.
- 2.2. Зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх этгээдийн өөрийн хөрөнгийн доод хэмжээ, Монголбанкнаас зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрөл олгоход баримтлах ажил үйлчилгээний шимтгэлийг Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар тогтооно.
- 2.3. Нэг иргэн, хуулийн этгээд нь 2 ба түүнээс дээш зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх этгээдэд хөрөнгө оруулахыг хориглоно.
- 2.4. Зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх этгээдийн удирдлагад ажиллах хүмүүст дараах шаардлага тавина:
 - 2.4.1. Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүн, Гүйцэтгэх захирлын ёс зүйн болон бизнесийн нэр хүнд нь зээлийн мэдээллийн санг удирдахад харшилах зүйлгүй байх;

2.4.2. Гүйцэтгэх захирал нь дээд боловсролтой, ял шийтгэл эдэлж байгаагүй, банк, санхүүгийн байгууллагад хугацаа хэтэрсэн өр зээлгүй, 5-аас дээш жилийн мэргэжлийн дадлага туршлагатай байх;

2.4.3. Эрх бүхий албан тушаалтан нь дээд боловсролтой ял шийтгэл эдэлж байгаагүй, банк, санхүүгийн байгууллагад хугацаа хэтэрсэн өр зээлгүй, 3-аас дээш жилийн мэргэжлийн дадлага туршлагатай, ёс зүйтэй.

2.5. Зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрөл авах тухай хүсэлт /цаашид “хүсэлт” гэх/ гаргагч хүсэлт гаргахдаа ажил, үйлчилгээний шимтгэлийг Монголбанкинд төлнө. Монголбанк үйлчилгээ үзүүлэн зөвшөөрөл олгосон эсэхээс үл хамааран ажил, үйлчилгээний шимтгэлийг хүсэлт гаргагчид буцаан олгохгүй.

2.6. Монголбанк хүсэлтийг эх хувиар хүлээн авна. Гадаадын иргэн, хуулийн этгээдийн хувьд монгол, англи хэлээр тус бүр 2 хувь үйлдэж орчуулсан байна.

2.7. Хүсэлт гаргагч нь Зээлийн мэдээллийн тухай хуулийн 23.2-т заасан бичиг, баримтаас гадна дараах бичиг, баримтыг бүрдүүлэн Монголбанкинд ирүүлнэ:

2.7.1. Үүсгэн байгуулагчдын болон хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр (нэг үүсгэн байгуулагчийн хувьд түүний гаргасан шийдвэрийг үүсгэн байгуулах шийдвэр гэж үзнэ);

2.7.2. Байгууллагын дүрэм;

2.7.3. Оноосон нэрийн зөвшөөрлийг бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас авсан тодорхойлолт;

2.7.4. Байгууллагын бүтэц, үйл ажиллагааны зохион байгуулалтын төлөвлөгөө;

2.7.5. Эрсдэлийг тодорхойлох, үнэлэх, удирдах арга хэрэгсэл болон мэдээллийн нууцлалыг хэрхэн хангах, дотоод хяналтын зохистой тогтолцоог хэрхэн бүрдүүлэхийг тодорхойлсон баримт бичиг;

2.7.6. Эдийн засгийн эсрэг гэмт хэрэг болон Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх үйл ажиллагаанд оролцсон, оролцоогүй гэдгийг нотолсон гарын үсэг бүхий тодорхойлолт;

2.7.7. Компанид хувь нийлүүлэх хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр, гарал үүслийг нотлох баримт;

2.7.8. Зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэгч этгээд татаан буугдах үндэслэл, зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх этгээдийн удирдлагын буруутай үйл ажиллагаанаас иргэд, аж ахуй нэгжид учруулсан хохирлыг барагдуулах арга, хэлбэр, хариуцлага хүлээх зарчим, Төлөөлөн удирдах зөвлөлөөс байгуулах хороо, тэдгээрийн гишүүдийг томилох, чөлөөлөх журам, эрх, үүрэг, хариуцлага, /КТХуулиар ХХК-д ХШЗөвлөл байхгүй/ Дотоод аудит хариуцсан нэгжийн бүрэн эрх, үүрэг, хариуцлага зэргийг тусгасан журам;

2.7.9. Энэ журмын 2.4-т заасан шаардлагыг хангасныг нотлох баримт;

2.7.10. Ажлын байрны техник тоног төхөөрөмж, програм хангамж, ажлын байрны найдвартай, аюулгүй ажиллагаа, нууцлал, харуул, хамгаалалтын асуудлыг хэрхэн шийдвэрлэсэн талаар тодорхой бичиж ирүүлэх, холбогдох баримтыг хавсаргах;

2.7.11. Шаардлагатай гэж үзсэн бусад баримт бичиг.

2.8. Зээлийн мэдээллийн тухай хуулийн 23.2.4-т заасан бизнес төлөвлөгөө нь тухайн байгууллагын үйл ажиллагаа эхлүүлсний дараах 3 жилийн үйл ажиллагааг хамрах бөгөөд уг төлөвлөгөөнд доорх зүйлсийг тусгасан байна:

2.8.1. Үйл ажиллагааны дундаж зардал, үйлчилгээний хөлс зэргийг тусгасан санхүүгийн төлөвлөгөө байх бөгөөд уг төлөвлөгөөний дагуу тухайн байгууллага ашигтай ажиллаж байх шаардлагатай;

2.8.2. Зах зээлийн шинжилгээ, хэрэглэгчийн талаарх судалгаа;

2.8.3. Зээлдэгч Зээлийн мэдээллийн тухай хуулийн 22.1.1-т заасан эрхээ эдлэх боломжийг бүрдүүлсэнийг нотлох баримт;

2.8.4. Хэрэглэгчдэд бэлтгэн нийлүүлэх бүтээгдэхүүн, үйлчилгээний төлөвлөгөө.

2.9. Зээлийн мэдээллийн тухай хуулийн 23.2.1, 23.2.2-т заасан эрх бүхий этгээдүүдийн тухай мэдээллийг энэ журмын 1 дүгээр хавсралтад тусгасны дагуу Монголбанкинд ирүүлэх ба, өөрчлөлт орох тухай бүх шинэчлэлтийг тусган ажлын 10 хоногийн дотор Монголбанкинд ирүүлж байна.

2.10. Нэгээс дээш этгээд зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээд үүсгэн байгуулах тохиолдолд Компанийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан үүсгэн байгуулагчдын хамтран ажиллах зарчим, үүсгэн байгуулагч тус бүрийн эдлэх эрх, хүлээх үүрэг, хариуцлага болон өөрийн хөрөнгийн хэмжээ, бүтэц, хэлбэр, бүрдүүлэх хугацаа, түүний бүтцэд өөрчлөлт оруулах нөхцөл зэргийг тусгасан хамтран ажиллах гэрээг байгуулна.

2.11. Монголбанк нь тусгай зөвшөөрөл олгох эсэх шийдвэрийг Зээлийн мэдээллийн тухай хуулийн 23.3-т заасны дагуу хүсэлтийг хүлээн авсан өдрөөс хойш 30 хоногийн дотор гаргаж, энэ тухай хүсэлт гаргагчид бичгээр мэдэгдэнэ.

ГУРАВ. Зээлийн мэдээллийн сан байгуулахад бүрдүүлэх баримт бичгийг хянах, зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрөл олгох, татгалзах

3.1. Зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх этгээд байгуулахад шаардлагатай баримт бичгийн бүрдлийг энэ журмын 2 дугаар хавсралтад заасан жагсаалтын дагуу хүлээн авах бөгөөд баримт бичгийг бүрэн гүйцэд ирүүлсэн өдрийг хүсэлт хүлээн авсан өдөрт тооцно. Хэрэв баримт бичгийн бүрдэл дутуу бол энэ талаар хүсэлт гаргагчид албан бичгээр мэдэгдэнэ.

3.2. Монголбанк дор дурдсан зүйлийг шалгаж тогтоосны үндсэн дээр дүгнэлтээ гаргана:

3.2.1. Баримт бичгийг бүрэн, гүйцэд ирүүлсэн эсэх, тэдгээр нь Зээлийн мэдээллийн тухай хууль тогтоомж болон энэ журамд тавьсан заасан шаардлагад нийцэж байгаа эсэх;

3.2.2. Зээлийн мэдээллийн үйл ажиллагааны талаарх бодлого, үйл ажиллагааг тусгасан эрх зүйн баримт бичиг нь хууль тогтоомжид нийцсэн эсэх;

3.2.3. Мэдээллийн нууцлал аюулгүй байдлыг хангах, хэрэглэгч нарыг Зээлийн мэдээллийн тухай хуулинд заасан эрхээр хангах нөхцлийг бүрдүүлсэн эсэх;

3.2.4. Байгууллагын зохистой засаглал, зохион байгуулалт, байгууллагад учирсан болон учирч болзошгүй эрсдэлийг илрүүлэх, тодорхойлох, үнэлэх, дүгнэх чадвартай эсэх, хяналтын удирдлагын шат бүрт хэрэгжүүлэх давхар хяналтын системийг бүрдүүлж, хүлээх үүрэг, хариуцлагыг хууль тогтоомжид заасны дагуу тодорхой тусгаж чадсан эсэх;

3.2.5. Хүсэлт гаргагч хуулийн этгээдийн хувьцаа эзэмшигч, эрх бүхий албан тушаалтан нь зээлийн мэдээллийн үйл ажиллагааг эрхлэн явуулахад тавигдаж буй хууль, ёс зүйн шаардлага болон мэдлэг мэргэжил, ажлын ур чадварын шалгуурыг хангаж байгаа эсэх;

3.2.6. Зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх этгээдийн бизнес төлөвлөгөө нь журмын 2.8-т заасан шаардлагыг хангаж, тухайн байгууллагын гадаад болон дотоод хүчин зүйлсийн нөлөөллийг харгалзан үзэж, үйл ажиллагаа явуулах цар хүрээг оновчтой тодорхойлсон эсэх;

3.2.7. Үйлчилгээний хөлсийн хэмжээ нь бүтээгдэхүүний зардал, зах зээлийн эрэлттэй уялдсан эсэх;

3.2.8. Зээлийн мэдээллийн үйлчилгээ явуулах техник, тоног төхөөрөмж, програм хангамж, ажлын байрны аюулгүй, найдвартай ажиллагааг хангасан эсэх.

3.3. Ирүүлсэн баримт бичиг тэдгээрт холбогдох мэдээллийг энэ журам болон холбогдох бусад хууль тогтоомжид нийцэж буй эсэхийг шалгана.

3.4. Монголбанк нь шаардлагатай гэж үзсэн асуудлаар дотоод, гадаадын эрх бүхий байгууллага, тухайлбал шүүх, цагдаа, татвар, тусгай зөвшөөрөл олгодог байгууллага, Санхүүгийн мэдээллийн алба болон түүнтэй адилтгах байгууллага, аудит, банк болон бусад байгууллагаас тодорхойлолт, лавлагаа гаргуулан, мэргэжлийн байгууллага, газруудтай хамтран хяналт шалгалтыг хийж болно.

3.5. Хүсэлт гаргагчийг мэдээллийн технологийн хувьд энэ журамд заасан шаардлагыг хангаж байгаа эсэх талаарх дүгнэлтийг Монголбанкны Мэдээллийн технологийн газар ажлын 10 хоногийн дотор багтаан гаргана.

3.6. Хяналт шалгалтын газар нь тусгай зөвшөөрөл олгох, зөвшөөрлийн хугацааг сунгах хүсэлтийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу хянаж, шаардлагатай асуудлыг газар дээр нь шалгана. Зээлийн мэдээллийн тухай хууль болон энэ журмын 2 дугаар бүлэгт заасан шаардлагыг бүрэн хангасан гэж үзвэл, тусгай зөвшөөрөл олгох, сунгах асуудлын талаар санал боловсруулж, Монголбанкны Захирлуудын зөвлөлийн хуралд хэлэлцүүлэхээр оруулна.

3.7. Тусгай зөвшөөрөл олгох, хүчингүй болгох, түдгэлзүүлэх, сэргээх, сунгах асуудлыг Монголбанкны Захирлуудын зөвлөлийн хурлын шийдвэрийг үндэслэн Монголбанкны Ерөнхийлөгч шийдвэрлэнэ.

3.8. Хяналт шалгалтын газар нь зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх этгээд байгуулах тухай Монголбанкны Ерөнхийлөгчийн шийдвэрийг үндэслэн тухайн байгууллагыг бүртгэж, хувийн хэрэг нээн хөтөлнө.

3.9. Монголбанк нь дараах нөхцөлд зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрөл олгохоос татгалзана:

3.9.1. Тусгай зөвшөөрөл хүссэн бичиг баримтын бүрдэл дутуу мөн бүрдэл дутуу материалыг энэхүү журмын 3.1-т заасан үндэслэлээр буцааснаас хойш 60 хоногийн дотор холбогдох материалыг ирүүлээгүй;

3.9.2. Ирүүлсэн баримт материал нь Зээлийн мэдээллийн тухай хууль тогтоомж, журамд заасан шаардлагыг хангаагүй;

3.9.3. Зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх этгээд байгуулахаар бүрдүүлсэн баримт бичиг нь хуурамч, удирдлагад ажиллах хүмүүс нь журамд заасан шалгуурыг хангаагүй, өөрийн хөрөнгийг хууль ёсны үйл ажиллагааны орлогоос бүрдүүлээгүй;

3.9.4. Монголбанкнаас шаардсан мэдээлэл болон тухайн мэдээллийг нотлох баримтыг ирүүлээгүй, нотлох баримтын үндэслэл, тайлбар нь тодорхойгүй, тэдгээрийг тодорхойлох боломжгүй.

3.9.5. Монголбанк нь энэ журмын 3.7-д заасан үндэслэлээр зөвшөөрөл олгохоос татгалзсан тохиолдолд энэ тухай хүсэлтийн үүсгэн байгуулагч, хувьцаа эзэмшигчид бичгээр мэдэгдэнэ.

3.10. Тусгай зөвшөөрлийг 3 /турван/ жилийн хугацаатай олгоно. Тусгай зөвшөөрлийн хугацаа дууссан нөхцөлд Монголбанкнаас Зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх этгээдэд хийгдсэн шалгалтын дүн, тухайн этгээдийн үйл ажиллагаа явуулсан байдал зэргийг нягтлан хянаад, цаашид тусгай зөвшөөрлийн хугацааг сунгах шаардлагатай гэж үзвэл, хүсэлтийг үндэслэн тусгай зөвшөөрлийг 3 /турван/ жилээр сунгаж болох ба сунгалт хийх тоонд хязгаарлалт тавихгүй.

3.11. Зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх этгээд нь өөрийн оноосон нэрийн ард “зээлийн мэдээллийн сан” гэсэн нэр томьёог авч ашиглана.

3.12. Зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх байгууллага нь Зээлийн мэдээллийн тухай хуулийн 14.1.5-д заасан зээлийн мэдээлэлтэй холбоотой бусад үйлчилгээг эрхлэх зөвшөөрөл хүсэхдээ үйл ажиллагааны нэр төрөл, шаардлага, хөрөнгийн эх үүсвэр, тухайн үйл ажиллагааг явуулахад шаардагдах техник, тоног төхөөрөмж, програм хангамж, ажлын байр, удирдлага, хүний нөөц, санхүү, төлбөрийн чадварын талаар тодорхой тусгасан баримт бичгийг Монголбанкинд ирүүлнэ.

3.13. Хяналт шалгалтын газар нь зээлийн мэдээлэлтэй холбоотой бусад үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох хүсэлтийг хүлээн авч уг үйл ажиллагааны хэрэгцээ, шаардлагыг харгалzan үзэж, тусгай зөвшөөрөл олгох эсэх талаарх санал, дүгнэлтээ боловсруулна.

3.14. Хяналт шалгалтын газрын санал, дүгнэлт, холбогдох хууль тогтоомжийг үндэслэн зээлийн мэдээллийн сангийн бусад үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох шийдвэрийг Монголбанкны Ерөнхийлөгч гарган, зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх этгээдэд бичгээр мэдэгдэнэ.

ДӨРӨВ. Зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэгч этгээдийн үйл ажиллагаанд тавих шаардлага, мөрдөх стандарт

4.1. Зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх этгээд нь журмын 3 дугаар хавсралтад заасан мэдээллийн технологийн стандартыг мөрдөж ажиллана.

4.2. Монголбанкнаас журмын 3 дугаар хавсралт дах стандарт, шаардлагыг жил бүр хүлээн авч, шаардлагатай нэмэлт, өөрчлөлтийг тухай бүр оруулж байна.

4.3. Зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх этгээд нь мэдээллийн аюулгүй байдлыг хангах, нууцлалыг хадгалах, зүй бус хэрэглээнээс урьдчилан сэргийлэх, гадны халдлагаас хамгаалах тогтолцоог өөрийн үйл ажиллагаандаа бүрдүүлэх ба үүнд дараах зүйлс агуулагдсан байна:

4.3.1. Мэдээллийн болон мэдээллийн системийн тоног төхөөрөмжийн аюулгүй байдал, системийн хандалтад тавих хяналт, системд хор учруулах програмтай тэмцэх арга хэмжээ зэргийг тусгасан байгууллагын хэмжээний нэгдсэн аюулгүй байдлын бодлогыг баталж, хэрэгжүүлэх;

4.3.2. Мэдээллийг солилцох, боловсруулах, хадгалах, хамгаалах, ашиглах, шилжүүлэх үйл ажиллагаанд оролцогчдын эрх, үүргийг тодорхой зааж өгсөн дүрэм, журмын дагуу хийж гүйцэтгэдэг байх;

4.3.3. Зээлийн мэдээллийн сангийн үйл ажиллагаа, өөрийн байгууллагын үйлчилгээ, зээлдэгчийн зээлжих чадварыг үнэлэх аргазүйн талаарх ерөнхий мэдээлэл, хийж гүйцэтгэсэн ажил, зээлийн мэдээллийн сангийн үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалтын талаарх танилцуулга, сургалтыг бүх төрлийн мэдээллийн сувгийг ашиглан өөрийн байгууллагын ажилтнууд, харилцагч байгууллага болон олон нийтийн дунд тогтмол зохион байгуулах;

4.3.4. Эрх бүхий байгууллагаас батлан гаргасан холбогдох хууль, дүрэм, журмын биелэлтийг хангах, илэрсэн зөрчил, дутагдлын мөрөөр зохих арга хэмжээг тухай бүр авч байх;

4.3.5. Байгууллагын дотоод дүрэм, журмыг тогтмол шинэчилж, шаардлагатай өөрчлөлтийг нэн даруй хийдэг байх;

4.3.6. Байгууллагын хэвийн, тасралтгүй үйл ажиллагааг хангах нөөц төлөвлөгөөг боловсруулж мөрдөх, төлөвлөгөөг жилд нэгээс доошгүй удаа туршиж шаардлагатай өөрчлөлтийг хийдэг байх;

4.3.7. Давагдашгүй хүчин зүйлсээс хамгаалах Зээлийн мэдээллийн сангийн нөөц төвтэй байх;

4.3.8. Зээлийн мэдээллийн тухай хуулийн 22.1.1-т заасан зээлдэгчийн эрхийг хангах боломжийг бүрдүүлэх;

4.3.9. Зээлдэгчийн талаар лавлагаа авах тухай бүр уг лавлагааг авсан огноо, авсан этгээд зэрэг мэдээллийг тусгасан лавлагааны түүх хөтлөх ба дараачийн лавлагаанд эдгээр мэдээлэл тусгагдаж байх.

4.4. Зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх этгээд нь мэдээллийг хамтран ажиллах гэрээ бүхий байгууллагаар дамжуулан түгээж болох бөгөөд энэ харилцааг гэрээгээр зохицуулна.

4.5. Зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх этгээд зээлийн мэдээллийн талаарх аливаа гомдол, хүсэлтийг холбогдох хууль журмын дагуу түргэн шуурхай шийдвэрлэх бөгөөд гомдол, хүсэлтийг шийдвэрлэх ажлыг хариуцсан ажилтантай байна.

**TAB. Зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэгч этгээдийн
үйл ажиллагаанд тавих хяналт**

5.1. Зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх этгээдийн үйл ажиллагаанд тавих хяналт шалгалтыг Монголбанкны хянан шалгагч хэрэгжүүлнэ.

5.2. Монголбанкны хянан шалгагч Зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх этгээдийн ажилтан, эрх бүхий албан тушаалтанаас шаардлагатай тайлан, мэдээ мэдээллийг үнэн зөвөөр гаргуулан авах, газар дээрхи шалгалт хийх нөхцлөөр хангагдсан байна.

5.3. Монголбанкны хянан шалгагч дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

5.3.1. Зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх этгээдийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа тоног төхөөрөмж, програм хангамжид нэвтрэх, тэдгээрээс үйл ажиллагааны тайлан мэдээ, мэдээллийг цахим болон бусад хэлбэрээр хувилан авах;

5.3.2. Зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх этгээдийн байр, тасалгаа, бусад холбогдох газарт нэвтрэн орох;

5.3.3. Зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх этгээдийн програм хангамж, данс бүртгэл, тайлан, тэнцэл, санхүүгийн баримтад хяналт шалгалт хийх, тайлбар, лавлагaa гаргуулж авах, асуулт тавьж, хариулт авах;

5.3.4. Шаардлагатай магадлагаа, баримтын хуулбарыг уг зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх этгээд, түүний харилцагч иргэн, хуулийн этгээд банк, санхүүгийн болон бусад байгууллагаас үнэ төлбөргүй гаргуулан авах;

5.3.5. Зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх этгээд, түүний үйл ажиллагаатай холбогдсон хууль тогтоомжийг зөрчсөн гэм буруутай этгээдэд холбогдох хууль тогтоомжийн дагуу захиргааны хариуцлага хүлээлгэх;

5.3.6. Хууль тогтоомж зөрчсөн нь гэмт хэргийн шинжтэй байвал холбогдох баримт бичгийг эрх бүхий байгууллагад шилжүүлэх.

5.4. Зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх этгээдийн үйл ажиллагаанд хийх хяналт нь газар дээрх шалгалт болон зайнаас тавих хяналт гэсэн үндсэн 2 хэлбэртэй байна.

5.5. Зайнаас тавих хяналтыг энэ журмын 5.7-д тусгасан тайлан, мэдээлэл болон холбогдох бусад баримт, материалд тулгуурлан холбогдох хууль тогтоомж, Монголбанкны дүрэм, журам, заавраар тогтоосон шалгуур, стандартыг ханган ажиллаж байгаад улирал бүр дүгнэлт хийж хэрэгжүүлнэ.

5.6. Хяналт шалгалтын газрын хянан шалгагч нь улирал бүр Зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх этгээдийн үйл ажиллагааны талаарх дүгнэлт, уг дүгнэлтийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай саналыг боловсруулж Хяналт шалгалтын газрын удирдлагад танилцуулна.

5.7. Дараах тайлан мэдээг улирал бүрийн эцсийн байдлаар дараа сарын 15-ны өдрийн дотор Монголбанкинд цаасаар болон цахим хувилбараар ирүүлнэ:

5.7.1. Тайлант хугацаанд гарсан зөрчил, дутагдал, гомдол, санал тэдгээрийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан;

5.7.2. Зээлийн мэдээллийн сангийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаанд учирсан зөрчил, дутагдал тэдгээрийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан;

5.7.3. Мэдээлэл нийлүүлэгчдийн жагсаалт, өмнөх тайлант хугацаанаас хойш шинээр нэмэгдсэн мэдээлэл нийлүүлэгч;

5.7.4. Бүтээгдээхүүн үйлчилгээ, тэдгээрийн борлуулалтын талаарх дэлгэрэнгүй тайлан;

5.7.5. Тайлант хугацаанд хийгдсэн дотоод аудитын ажлын дэлгэрэнгүй тайлан;

5.7.6. Санхүүгийн тайлан;

5.7.7. Шаардлагатай гэж үзсэн бусад тайлан, мэдээлэл.

5.8. Монголбанкны хянан шалгагч нь Зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх этгээдээс ирүүлсэн тайлан, мэдээлэл дээр тулгуурлан дараах дүн шинжилгээг хийнэ:

5.8.1. Холбогдох хууль тогтоомж, заавар журмын дагуу үйл ажиллагаа явуулж байгаа эсэх;

5.8.2. Тайлант хугацаанд зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх этгээдийн сул тал болон буруутай үйл ажиллагааны улмаас зөрчил, дутагдал гарсан эсэх;

5.8.3. Хэрэглэгчдийн зүгээс ирүүлсэн гомдол, саналыг хууль, журмын дагуу шийдвэрлэсэн эсэх;

5.8.4. Бүтээгдээхүүн, үйлчилгээ нь хууль тогтоомж, журамд нийцэж байгаа эсэх;

5.8.5. Санхүүгийн тайлангийн дүн шинжилгээ.

5.9. Зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх этгээдээс ирүүлсэн тайлан мэдээлэлд хийсэн дүн шинжилгээнд зөрчил, дутагдал илэрсэн тохиолдолд хянан шалгагч нь хууль, журмын дагуу холбогдох арга хэмжээг авч, уг зөрчил дутагдлыг арилгуулах талаар хугацаатай үүрэг даалгаврыг зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх этгээдэд өгч, биелэлтэд хяналт тавина.

5.10. Монголбанкнаас зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх этгээдийн үйл ажиллагаанд хийгдэж буй хяналт шалгалтын дүнд үндэслэн зээлийн мэдээллийн сангийн үйл ажиллагаанд учирч болзошгүй эрсдэлийг тодорхойлж, энэ талаарх мэдээллийг зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх этгээдэд хүргүүлж байна.

5.11. Монголбанкнаас зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх этгээдэд газар дээрх шалгалтыг нь иж бүрэн болон хэсэгчилсэн гэсэн 2 хэлбэртэй хийх бөгөөд газар дээрх иж бүрэн шалгалтыг жилд нэгээс доошгүй удаа хийж гүйцэтгэнэ.

5.12. Монголбанкнаас газар дээрх иж бүрэн шалгалтыг хийх ажлын хэсгийн бүрэлдэхүүнд мэдээллийн технологийн мэргэжилтэн байх ба уг мэргэжилтэн нь мэдээллийн нууцлалыг хангах гэрээ бүхий гуравдагч байгууллагын ажилтан байж болно.

5.13. Монголбанкнаас газар дээрх иж бүрэн шалгалтыг энэ журмын 4 дүгээр хавсралтад тусгасан удирдамжийн дагуу хийж гүйцэтгэх бөгөөд шаардлагатай тохиолдолд нэмэлт асуудал тусгаж болно.

5.14. Энэ журмын 4 дүгээр хавсралтад тусгасан удирдамжийн дагуу зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх этгээдэд хийгдэх газар дээрх шалгалтын үнэлгээний аргачлалыг Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар батална.

5.15. Зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх этгээдийг шалгасан газар дээрх шалгалтын мөрөөр Монголбанкны хянан шалгагч нь зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх этгээдэд хугацаатай үүрэг, даалгавар өгч биелэлтийг хангуулах ба шаардлагатай нөхцөлд тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох тухай асуудлыг Монголбанкны Ерөнхийлөгчид танилцуулж шийдвэрлүүлнэ.

5.16. Зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх этгээд нь өөрийн үйлчилгээний хөлсний хэмжээнд өөрчлөлт оруулахдаа Монголбанкнаас зөвшөөрөл авна. Ингэхдээ үйлчилгээний хөлсний хэмжээнд өөрчлөлт оруулах шаардлага, эдийн засгийн үндэслэлийг тусгасан танилцуулга бүхий хүсэлтийг Монголбанкинд ирүүлнэ.

5.17. Монголбанкнаас журмын 5.22-д заасан хүсэлттэй танилцаж үйлчилгээний хөлсний хэмжээнд өөрчлөлт оруулах үндэслэлийг бодитой гэж үзвэл үйлчилгээний хөлсийг өөрчлөх зөвшөөрлийг зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх этгээдэд олгоно.

5.18. Зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх этгээд нь Монголбанкны хүлээн зөвшөөрсөн хөндлөнгийн аудитын байгууллагаар баталгаажуулсан жилийн эцсийн тайланг дараа жилийн эхний 3 сарын дотор Монголбанкинд ирүүлнэ.

ЗУРГАА. Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох

6.1. Монголбанк дараах үндэслэлээр тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох шийдвэр гаргана:

6.1.1. Зээлийн мэдээллийн тухай хуулийн 26.1-т заасан үндэслэлээр;

6.1.2. Зээлийн мэдээллийн сангийн үйл ажиллагааг түдгэлзүүлсэн шалтгааныг арилгалгүйгээр тухайн үйл ажиллагааг үргэлжлүүлэн эрхэлсэн, эсхүл 6 сарын хугацаанд түдгэлзүүлсэн тухай шийдвэрийг цуцлах хангалттай нөхцөл бүрэлдээгүй бол;

6.1.3. энэ журмын 5.15-д заасан үндэслэлээр;

6.1.4. Зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэгч этгээдийн хувьцаа эзэмшигчдийн хурлаар тухайн хуулийн этгээдийг татан буулгах, өөрчлөн байгуулах тухай шийдвэр гарсан.

6.2. Тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон тохиолдолд тухайн этгээд Монголбанкнаас олгосон зөвшөөрлийн гэрчилгээг 7 хоногийн дотор Хяналт шалгалтын газарт хүргүүлнэ. Хяналт шалгалтын газар гэрчилгээн дээр “Хүчингүй” гэсэн тэмдэг дарж, тухайн байгууллагын хувийн хэрэгт хийн, зохих журмын дагуу архивт шилжүүлнэ.

6.3. Монголбанк нь зээлийн мэдээллийн сангийн эрхэлж буй үйл ажиллагааг дараах үндэслэлээр түдгэлзүүлэх буюу хүчингүй болгож болно:

- 6.3.1. Зээлийн мэдээллийн тухай хуулийн 25.1, 26.1-т заасан үндэслэлээр;
 - 6.3.2. Зээлийн мэдээллийн тухай хууль тогтоомжийг зөрчсөн;
 - 6.3.3. энэ журмын 5.15-д заасан үндэслэлээр;
 - 6.3.4. Зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэгч этгээд өөрөө хүсэлт гаргасан;
 - 6.3.5. Хууль тогтоомжид заасан бусад үндэслэл.
- 6.4. Зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх этгээд нь энэ журмын 6.3-т заасан үндэслэлээр түдгэлзүүлсэн тусгай зөвшөөрлийг сэргээлгэх хүсэлтийг Монголбанкинд тавьсан нөхцөлд тухайн зөрчил дутагдлыг арилгасан байдал, энэ талаар өгсөн үүрэг, даалгаврын биелэлт зэргийг газар дээрх хэсэгчилсэн буюу иж бүрэн шалгалтаар тогтоож, уг шалгалтын дүгнэлтийг үндэслэн тусгай зөвшөөрлийг сэргээх эсэхийг шийдвэрлэнэ.
- 6.5. Монголбанк нь тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон тухай нийтэд мэдээлнэ.

ДОЛОО. Хяналт, хариуцлага

- 7.1. Зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх этгээдийн өөрийн хөрөнгийн хэмжээ, бүтцэд өөрчлөлт оруулах явц, түүний нягтлан бодох бүртгэлийн ажиллагаанд тухайн этгээдийн Төлөөлөн удирдах зөвлөл, Дотоод аудит хариуцсан нэгж хяналт тавьж ажиллана.
- 7.2. Монголбанкны зөвшөөрөлгүйгээр зээлийн мэдээллийн сан үүсгэж, зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлсэн этгээдэд Зээлийн мэдээллийн тухай хуулийн 29.1-т заасан захиргааны арга хэмжээ авна.
- 7.3. Монголбанк энэ журмын биелэлтэд хяналт тавьж, Зээлийн мэдээллийн тухай хууль тогтоомж, журмыг зөрчсөн этгээдэд хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

ооо



**Зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх этгээдийн үүсгэн байгуулаа
эрх бүхий этгээдийн тодорхойлолтын загвар**

Хавсралт 1

- Үүсгэн байгуулагч
 - Хувьцаа эзэмшигч
 - Гүйцэтгэх захирал
 - Газар (хэлтэс)-ийн захирал
(аль нь болохыг дотор тэмдэглэгээ хийх)

(Үүсгэн байгуулагч, хувьцаа эзэмшигч нь иргэн бол:)

1. Нэр
 2. Эцгийн нэр Ургийн овог
 3. Иргэний харьяалал
 4. Регистрийн дугаар:
 5. Ажлын хаяг
 6. Оршин суугаа газрын хаяг
 7. Гар утасны дугаар
 8. Ажлын утасны дугаар
 9. Имэйл хаяг

(иргэний үнэмлэхний нотариатаар гэрчилсэн хуулбарыг хавсаргана)

10. Боловсрол:

Хаана /улс болон хотын нэр/ эзэмшсэн	Сургуулийн нэр /сурсан хугацаа/	Эзэмшсэн боловсрол/ хамгаалсан цол/	Эзэмшсэн мэргэжил

11. Ажлын туршлага:

Ажилласан байгууллага, албан тушаалын нэр	Ажилласан хугацаа

12. Галаад хэлний мэдлэг, түвшин:

13. Хөрөнгө оруулж, хувьцаа эзэмшиж буй аж ахуй нэгжийн нэр, оруулсан хөрөнгийн хэмжээ:

(Зөвхөн хувьцаа эзэмшигчдээд хамаарна)

Боловсон хүчний тодорхойлолтыг үнэн зөв бичсэн: (.....)
гарын үсэг нэр

Огноо: 20 . . . оны . . . дутгээр сарын . . . -ны өдөр.

(Үүсгэн байгуулагч, хувьцаа эзэмшигч нь хуулийн этгээд бол:)

1. Оноосон нэр:	2. Улсын бүртгэлийн дугаар: 3. Регистрийн дугаар:
4. Байгуулагдсан огноо:	5. Хуулийн этгээдийн улсын харьяалал:
6. Байршил/Хаяг:	
7. Өөрийн хөрөнгийн өмчлөл:	8. Зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх этгээдэд өөрийн хөрөнгөд оруулсан хэмжээ (төгрөгөөр)
9. Ерөнхий захирлын буюу эзний овог нэр:	10. Регистрийн дугаар:
11. Гүйцэтгэх захирлын овог нэр:	12. Регистрийн дугаар:

13. Хуулийн этгээдийн удирдлагын түүх:

Тухайн хуулийн этгээдийн ерөнхий захирал буюу эзэн үүнээс өмнө өөрчлөгдөж байсан бол байгуулагдсан цагаас хойши ажиллааж байсан захирлуудын нэр, регистрийн дугаарыг бичнэ:

- 1) овогтой..... Регистрийн дугаар.....
2) овогтой..... Регистрийн дугаар.....

Тухайн хуулийн этгээдийн гүйцэтгэх захирал үүнээс өмнө өөрчлөгдөж байсан бол байгуулагдсан цагаас хойши ажиллааж байсан захирлуудын нэр, регистрийн дугаарыг бичнэ:

- 1) овогтой..... Регистрийн дугаар.....
2) овогтой..... Регистрийн дугаар.....

14. Хуулийн этгээдийн үйл ажиллагаатай холбогдсон танилцуулга:

Эрхэлдэг үйл ажиллагаа:

Салбар, хараат болон охин компанийтай бол:

Нэр, байршил Улсын бүртгэлийн дугаар.....
Регистрийн дугаар Харилцагч банкны нэр:

15. Өөр аж ахуйн нэгжийн хувьцаа эзэмшигч бол тэдгээрийн нэр:

(Одоо зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх этгээдэд нийлүүлсэн хоронгөд оруулж байгаа хөрөнгийн эх үүсвэр, тухайн аж ахуйн нэгж буюу түүнд хамааралтай хуулийн этгээд нь бусдад өр, зээлтэй эсэх, захирал эзэн нь аливаа асуудлаар ял шийтгэгдэж байсан эсэх, одоо хууль хяналтын байгууллагад хэрэг үүсгэгдсэн эсэх зэргийг бичнэ)

**Зээлийн мэдээлийн үйлчилгээ үзүүлэх этгээд байгуулахад шаардлагатай
баримт бичгийн бүрдлийг шалгах хүснэгт**

Хүснэгтийг хүлээн авсан огноо:

20.....оныдугаар сарын-ны өдөр

- Хүснэгтийг хар өнгийн балаар зөвхөн гараар бөглөнө
- Тухайн баримт бичгийг ирүүлсэн болон дутуу буюу огт ирүүлээгүйг харгалзах баганын хоосон нүдэнд ✓ тэмдэглэгээгээр зурж тэмдэглэнэ.
- Хувьцаа эзэмшигчийн тоо _____

Д/д	Баримт бичгийн нэр	Ирүүлсэн	Ирүүлээгүй
1.	Зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх этгээд байгуулах тухай хүсэлт		
2.	Зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх этгээд үүсэн байгуулах гэрээ (иэг үүсгэн байгуулагчтай бол банк үүсгэн байгуулах шийдвэр)		
3.	Үүсгэн байгуулагчдын хурлын албан ёсны шийдвэр		
4.	Оноосон нэрийн зөвшөөрлийг бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас авсан тодорхойлолт		
5.	Зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх этгээдийн хувьцаа эзэмшигч, эрх бүхий албан тушаалтан нь энэхүү журмын 1 дүгээр хавсралтын гаргасан тодорхойлолт болон дараахь бичиг баримт: <ul style="list-style-type: none"> • Зээл, батлан даалтын гэрээгээр хүлээсэн хугацаа хэтэрсэн аливаа өртэй эсэх талаарх банк, шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх бүхий төрийн захиргааны байгууллага, зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх эрх бүхий этгээдийн тодорхойлолт; • Гааль, татварын байгууллагад сүүлийн 3 жилд төлсөн татварын баримт болон өртэй эсэх талаар эдгээр байгууллагын удирдлагын гарын үсэгтэй тодорхойлолт; • Ял шийтгэлтэй эсэх талаар цагдаагийн байгууллагын тухайн асуудал хариуцсан нэгжийн удирдлагын гарын үсэгтэй тодорхойлолт; • Эдийн засгийн эсрэг гэмт хэрэг болон мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх үйл ажиллагаанд оролцсон, оролцоогүй гэдгийг нотолсон гарын үсэг бүхий тодорхойлолт. 		
6.	Зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх этгээдэд хувь нийлүүлэх хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр, гарал үүслийг нотлох баримт: <ul style="list-style-type: none"> • Монголбанкнаас тогтоосон өөрийн хөрөнгийн доод хэмжээнээс доошгүй хөрөнгийг хуримтлуулсаныг нотлох баримт; • Тухайн хуулийн этгээдийн 5-аас дээш хувийн эзэмшигч нь аж ахуйн нэгж бол харьялах татварын байгууллагаас баталгаажуулсан сүүлийн 3 жилийн “Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тайлан”, иргэн бол сүүлийн 3 жилийн орлогын эх үүсвэрийг нотолсон баримт; • Бусад шаардлагатай гэж үзсэн мэдээлэл. 		

7.	<p>Зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх этгээдийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүн, Гүйцэтгэх удирдлагын талаар энэ журмын 2 дугаар хавсралтын дагуу гаргасан тодорхойлолт болон дараахь бичиг баримт:</p> <ul style="list-style-type: none"> Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүн, Гүйцэтгэх захирлын ёс зүйн болон бизнесийн нэр хүнд нь зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх этгээдийг удирдахад харшлах зүйлгүйг тодорхойлсон үүсгэн байгуулагчид болон хувьцаа эзэмшигчдийн хурлын даргын тодорхойлолт; Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүн, гүйцэтгэх захирал нь журмын 2.4-т заасан шаардлага, шалгуурыг хангаж байгаа тухай хувьцаа эзэмшигчдийн хурлын даргын тодорхойлолт, эрх бүхий төрийн захиргааны байгууллагуудын тодорхойлолт, нотлох баримтын хамт. 	
8.	Зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх этгээдийн дүрэм	
9.	<p>Зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх этгээд байгуулах эдийн засгийн үндэслэл:</p> <ul style="list-style-type: none"> Байгууллагын бизнес төлөвлөгөө; Эхлэлтийн тайлан тэнцэл. 	
10.	<p>Ажлын байр, техник, тоног төхөөрөмж, програм хангамжтай холбоотой тодорхойлолт:</p> <ul style="list-style-type: none"> Зээлийн мэдээллийн сангийн аюулгүй байдлыг хамгаалах бүх шаардлагыг хангахуйц мэдээллийн системийн програм хангамж, техник хэрэгслээр хангагдсаныг нотлох баримт; Зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх этгээд байрлах байр, барилгыг худалдаж авсан бол үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээний нотариатаар гэрчлүүлсэн хуулбар, түрээсэлж байгаа бол түрээсийн гэрээ; Ажлын байр нь техник, тоног төхөөрөмжийн найдвартай байдлыг хангасан эсэхийг нотолсон баримт; Харуул хамгаалалтын байгууллагатай хамтран ажиллах гэрээ Бусад шаардлагатай баримт, материал. 	
11.	<p>Зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх этгээдийн үйл ажиллагааны зохион байгуулалт, төлөвлөлттэй холбоотой баримт бичиг:</p> <ul style="list-style-type: none"> Байгууллагын бүтэц, үйл ажиллагааны зохион байгуулалтын төлөвлөгөө; Байгууллагын эрсдэлийг илрүүлэх, тооцох, хэмжих, үнэлэх, дүгнэх, удирдах арга хэрэгсэл болон мэдээллийн нууцлалыг хэрхэн хангах, дотоод хяналтын зохистой механизмыг хэрхэн бүрдүүлэхийг тодорхойлсон баримт бичиг; Байгууллагын дотоод, гадаад үйл ажиллагааны зарчим, хариуцлагыг тусгасан ёсзүйн дүрэм; Үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах бодлогын чанартай эрх зүйн баримт бичиг; Хэрэглэгчтэй байгуулах гэрээний загвар; 	

	<ul style="list-style-type: none"> Зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэгч этгээд татан буугдах үндэслэл, зээлийн мэдээллийн сангийн удирдлагын буруутай үйл ажиллагаанаас харилцагчдад учруулсан хохирлыг барагдуулах арга хэлбэр, хариуцлага хүлээх зарчим: Төлөөлөн удирдах зөвлөлөөс байгуулах хороо, тэдгээрийн гишүүнийг томилох, чөлөөлөх журам, эрх, үүрэг, хариуцлага, Хянан шалгах зөвлөл, Дотоод аудитын газрын бүрэн эрх, үүрэг, хариуцлага зэргийг тусгасан журам. 	
12.	Монголбанкны ажил үйлчилгээний шимтгэл төлсөн баримт.	

Баримт бичгийн бүрдэл шаардлага хангасан бол:

ХХК-ийн байгуулагчдаас ирүүлсэн зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх этгээд үүсгэн байгуулах хүсэлт, холбогдох баримт бичгийн бүрдэл бүрэн гүйцэд тул 20. . . оны . . . дугээр сарын . . . -ны өдөр хүлээж авсан болохыг зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх этгээд үүсгэн байгуулагчдад Монголбанкны 20. . оны . . . дугээр сарын . . . -ны өдрийн тоот албан бичгээр мэдэгдэв.

Баримт бичгийн бурдлийг шалгасан:

ХШГ-ын хянан шалгагч (.)
гарын үсэг нэр

Хянасан:

ХШГ-ын хэлтсийн захирал(.....)
гарын үсэг нэр

ХШГ-ын захирал (.)
гарын усэг нэр

Танилшсан:

Тэргүүн дэд Ерөнхийлөгч (.)
гарын усэг нэр

Баримт бичгийн бурдэл шаардлага хангаагүй бол:

ХХК-ийн байгуулагчдаас ирүүлсэн зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх этгээд байгуулах хүсэлт, холбогдох баримт бичгийн бүрдэл бүрэн бус тул Монголбанкны 20 . .оны . . дүгээр сарын . . . -ны өдрийн тоот албан бичгээр мэдэгдэв.

Дутуу баримтын жагсаалт:

- 1)
2)

Баримт бичгийн бурдлийг шалгасан:

ХШГ-ын хянан шалгагч (.....)
гарын үсэг нэр

Хянасан:

ХШГ-ын хэлтсийн захирал(.....)
гарын үсэг нэр

ХШГ-ын захирал (.)
гарын үсэг нэр

Танилцсан:

Тэргүүн дэд Ерөнхийлөгч (.)
гарын үсэг нэр

Зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх этгээдийн мөрдөж ажиллах стандартын жагсаалт

- | | |
|---|--|
| 1. MNS 5969:2009 | Мэдээллийн технологи-Аюулгүй байдлын арга техник-Мэдээллийн аюулгүй байдлын эрсдэлийн удирдлага |
| 2. MNS 25030:2010 | Програм хангамжийн боловсруулалт Програм хангамжийн бүтээгдэхүүний чанрын шаардлага болон үнэлгээ(Square)-chanaryn шаардлагууд |
| 3. MNS 6197:2011 | Мэдээллийн технологи-Аюулгүй байдлын арга-Мэдээллийн технологийн сүлжээний аюулгүй байдал-1-р хэсэг:Сүлжээний аюулгүй байдлын удирдлага |
| 4. MNS 6242-2:2011 | Мэдээллийн технологи-Аюулгүй байдлын арга-Мэдээллийн технологийн сүлжээний аюулгүй байдал-2-р хэсэг:Сүлжээний аюулгүй байдлын архитектур |
| 5. MNS ISO 12207: | Програм хангамж боловсруулах үйл ажиллагааны циклууд |
| 6. MNS ISO 10011-1: | Системийн чанaryn шалгалтын удирдамжууд |
| 7. MNS ISO/IEC 27001:2009 | Мэдээллийн технологи:Аюулгүй байдлын арга техник-Мэдээллийн аюулгүй байдлын удирдлагын тогтолцоо-шаардлага |
| 8. MNS ISO 27002:2007 | Мэдээллийн аюулгүй байдал-Аюулгүй байдлын аргачлал-Мэдээллийн аюулгүй байдлын удирдлагын үйл ажиллагааны дүрэм |
| 9. MNS ISO/IEC 13335-1:2009 | Мэдээллийн технологи-Аюулгүй байдлын арга техник-Мэдээллийн ба холбооны технологийн байдлын удирдлага-1-р хэсэг: Мэдээлэл холбооны технологийн аюулгүй байдлын үндсэн ойлголтууд болон загварууд |
| 10. IEEE 829: | Програм хангамж турших болон баримт бичигжүүлэлтийн стандарт |
| 11. ANSI/IEEE SRS Standart 830-1984: | Системийн шаардлагын тодорхойлолт гаргах стандарт |

ооо

Зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх этгээдэд хийгдэх газар дээрх иж бүрэн шалгалтын удирдамж

Зээлийн мэдээллийн тухай хууль, тогтоомж, Монголбанкны Ерөнхийлөгчийн баталсан журам, зааврыг зээлийн мэдээллийн үйлчилээ үзүүлэх этгээдэд хэрхэн биелүүлж байгаа талаар үнэлгээ дүгнэлт хийхдээ Монголбанкны хянан шадгагч нь доорх удирдамжийг мөрдлөг болгоно.

Зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх этгээдэд хийгдэх газар дээрх иж бүрэн шалгалтаар дараах хучин зүйлсүүдийг авч үзнэ. Үүнд:

1. Байгууллагын зохистой засаглал, удирдлагын ур чадвар

- 1.1. Удирдлагын ур чадвар, Төлөөлөн удирдах зөвлөл, Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороодын үйл ажиллагаа;
- 1.2. Өргөдөл, гомдол шийдвэрлэсэн байдал;
- 1.3. Бүтээгдэхүүн, үйлчилгээг хэрэглэгчдэд хүргэж буй байдал;

2. Мэдээллийн технологийн аюулгүй байдлын тогтолцоо

- 2.1. Мэдээллийн сангийн үйл ажиллагаанд авч хэрэгжүүлж буй аюулгүй байдлын бодлого;
- 2.2. Гуравдагч этгээдээс авч буй бүтээгдэхүүн үйлчилгээ;
- 2.3. Сүлжээний гадаад дотоод холболт, хандалтын аюулгүй байдал;
- 2.4. Техник болон програм хангамжийн шинэчлэгдсэн байдал;
- 2.5. Програм болон техник хангамжийн хувьд үүсэн бий болсон хүндрэлтэй нөхцөл байдлыг шийдвэрлэсэн байдал;
- 2.6. Монголбанкнаас баталсан стандартуудыг үйл ажиллагаандаа ашиглаж байгаа байдал;
- 2.7. Аюулгүй байдал хариуцсан боловсон хүчний нөөц бололцоо;
- 2.8. Мэдээлэл нийлүүлэгчээс мэдээлэл авч буй байдал.

3. Эрсдэлийн удирдлагын тогтолцоо

- 3.1. Байгууллагын зүгээс өөрийн үйл ажиллагаанд учирч болзошгүй эрсдэлийг тодорхойлж байгаа байдал;
- 3.2. Эрсдэлийн үнэлгээ аюулгүй байдлын удирдлага, бодлого, төлөвлөгөөнд тохирч байгаа эсэх;
- 3.3. Эрсдэлийн үнэлгээний үр ашигт байдал (мэдлэгт суурилсан олон талт байдал, системчилсэн байдал, нэгтгэх үйл явц, баримтжуулалт, дүрэм журмын шинэчлэлт, өөрчлөлт);
- 3.4. Системийн өөрчлөлт хийх, шинэ бүтээгдэхүүн үйлчилгээ гаргах зэрэгтэй эрсдэлийн дүн шинжилгээг уялдуулах байдал;
- 3.5. Эрсдэлийн үнэлгээний аргачлалаа шинэчлэх давтамж.

4. Аюулгүй ажиллагааны бодлого, стандарт

- 4.1. Хувийн нууцлалыг хангах, хэрэглэгчийг таних, магадлах байдал;
- 4.2. Үндсэн системийн аюулгүй байдал;
- 4.3. Хэрэглэгчийн ашиглаж буй төхөөрөмжүүд, тэдгээрийн аюулгүй байдал;
- 4.4. Бүх төрлийн үйл ажиллагаанд биечлэн хяналт тавих байдал;
- 4.5. Нууцлал, нууц хангах зорилго бүхий түлхүүрлэлтийг ашиглах байдал;

- 4.6. Системийг хортой код, программын халдлагаас хамгаалах;
- 4.7. Систем хөгжүүлэлтийн үед баримтлах бодлого, стандарт;
- 4.8. Мэдээлэлтэй харьцах, хамгаалах, дамжуулах, устгахтай холбоотой дүрэм журам;
- 4.9. Мэдээллийн бус бүтээгдэхүүн бэлтгэн нийлуулэгчдэд тавих хяналт;
- 4.10. Даатгал.

5. Зээлийн мэдээллийн сангийн нууцлал, хяналтын тогтолцоо

- 5.1. Байгууллагын хяналтын тогтолцоо, хяналт шалгалт хэрэгжүүлж байгаа байдал;
- 5.2. Аюулгүй байдлыг хувь хүн болон байгууллагын бүтэц зохион байгуулалтын хувьд хэрхэн хангаж байгаа эсэх;
- 5.3. Аюулгүй байдлыг хангах нэгжийн үйл ажиллагаа, холбогдох журам заавар;
- 5.4. Аюулгүй байдал хариуцсан нэгжийн боловсон хүчний чадавхи;
- 5.5. Үйл ажиллагааны зөрчил дутагдлыг илрүүлэх байдал, авч хэрэгжүүлсэн арга хэмжээ;
- 5.6. Зээлийн мэдээллийн сан дахь зүй бус хандалтаас сэргийлэх, хандалтын үед авч хэрэгжүүлсэн арга хэмжээ.

Монголбанкны Хянан шалгагч эдгээр хүчин зүйлс тус бүрээр зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх этгээдийн үйл ажиллагаанд журмын 5.14-т заасан үнэлэлт, дүгнэлтийг өгсөний дараагаар нэгдсэн үнэлгээг гаргах ба энэхүү нэгдсэн үнэлгээ, дүгнэлт болон, хууль, тогтоомж, журмын хэрэгжилтийг ханган ажиллаж байгаа байдалтай холбогдуулан цаашид авч хэрэгжүүлэх арга, хэмжээний талаарх саналыг боловсруулна.

ооо